

"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ" -ИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2024.12.24

Нэг. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх нийт 5 зорилго, 9 зорилтын 21 арга хэмжээ туссан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

Хоёр. Үнэлгээний дүн

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийт 5 зорилго, 9 зорилтын 21 арга хэмжээ туссанаас 1 арга хэмжээ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудалд хамаарч үнэлэх боломжгүй байна.

Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо үнэлэх боломжгүй арга хэмжээг оруулан тооцоогүй болно.

Нийт үнэлгээгээр Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **95.0** хувьтай байна.

Гурав. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний биелэлт

- Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувьтай - 16 арга хэмжээ;
- Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90 хувьтай - 2 арга хэмжээ;
- Зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувьтай -1 арга хэмжээ;

- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувьтай - 1 арга хэмжээ байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн
үндсэн чиглэлийн хэрэгжилт

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт (Хувиар)
1.	Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ	4	100.0
2.	Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ	5	84.0
3.	Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ	5	96.0
4.	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ	1	100.0
5.	Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	1	100.0
6.	Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ	1	100.0
7.	Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ	1	100.0
8.	Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ	1	100.0

9.	Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ	1	100.0
10.	Нийт	20	95.0

Гурав. Гарсан үр дүн

- Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг үзүүлэх олон улсын жишигт нийцсэн, ижил стандарт бүхий “Job center” төвийн үйл ажиллагааг эхлүүллээ.
- Төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчилж цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүллээ.
- Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоолоо.
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, ажлын байр бий болгохыг дэмжих, хадгалах чиглэлээр нийт 6 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Дөрөв. Зөвлөмж

1. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт тогтмол тавьж, хэрэгжилт удаашралтай арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах талаар цаг тухай бүрт арга хэмжээ авч ажиллах;
2. Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, зорилт, арга хэмжээг илүү оновчтой тодорхойлох;
3. Зорилт, арга хэмжээг яамны холбогдох газрууд хяналтад авч, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг тусган төлөвлөж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
4. Хэрэгжилтийг шалгуур үзүүлэлттэй нь уялдуулж, үр дагаврыг үнэлж, тухайн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр бодитой тайлагнах;
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хариуцлагыг сайжруулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**